

БАТЛАВ  
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
С.ЭНХБАЯР  
2024 оны ... дугаар сарын ... өдөр

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 10, 11, 12, 13, 14, 16, 21, 22, 23 ДУГААР ХОРООДЫН АЙЛ  
ӨРХИЙН НҮХЭН ЖОРЛОН, БОХИРЫН ЦООНГОГИЙГ АРИУТГАЖ ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ  
АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 05 дугаар сарын 31-ны өдөр

24-9/16.  
Дугаар .../...

Улаанбаатар хот

Ажлын цар хэмжээ:

Хөрсний бохирдлыг бууруулах, халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Хан-Уул дүүргийн 10, 11, 12, 13, 14, 16, 21, 22, 23 дугаар хороодын айл өрхүүдийн нийт 5105 нүхэн жорлон, 3082 бохирын цооногийг ариутгаж халдвартгүйжүүлэх бөгөөд Монгол улсад мөрдөгдөж байгаа дүрэм, журам, стандартыг мөрдлөг болгоно.

1	Ажлын нэр	Хан-Уул дүүргийн 10, 11, 12, 13, 14, 16, 21, 22, 23 дугаар хороодын айл өрхийн нүхэн жорлон, бохирын цооногийг ариутгаж халдвартгүйжүүлэх ажил
2	Ариутгал халдвартгүйжүүлэлтийн ажил гүйцэтгэх хугацаа	- Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээний хугацааг үндэслэл болгоно.
3	Захиалагч байгууллага	- Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
4	Гүйцэтгэгч байгууллага	<ul style="list-style-type: none"><li>Нийслэлийн эрүүл мэндийн газраас олгодог "Ахуйн хортон шавж, мэрэгч устгал ариутгал, халдвартгүйтгэл" тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллага;</li><li>Байгууллага нь химич, эрүүл ахуйч, эмч, хөдөлмөр, аюулгүй байдал эрүүл ахуй хариуцсан ажилтан, ариутгач, биологич зэрэг бүрэлдэхүүнтэй байна.</li><li>Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжээр бүрэн хангагдсан, тэдгээр нь аюулгүй ажиллагааны болон техник ашиглалтын шаардлагыг бүрэн хангасан байна.</li></ul> <p>Тоног төхөөрөмж, хувцас хэрэглэл:</p> <ul style="list-style-type: none"><li>Хамгаалалтын хувцас хэрэгсэл (нэг удаагийн малгай, шүүлтүүртэй амны хаалт, нүүрний хаалт, бээлий, ханцууйч, комбинзон, ус нэвтрэхгүй түрийтэй гутал гэх мэт);</li><li>Автомакс (мананцар үүсгэгч)</li><li>Усмал найруулах сав, хэмжээст сав</li><li>Хэмжээст сав</li><li>Туузан тест /найруулсан уусмалыг шалгах/</li></ul>
5	Ариутгал халдвартгүйжүүлэлт хийх үе шат	Нүхэн жорлон, бохирын цооногт ариутгал халдвартгүйжүүлэлт хийхдээ:

		<ul style="list-style-type: none"> <li>- Нүхэн жорлонд үнэр дарах, ариутгаж халдвартгүйжүүлэх үйлчилгээтэй ашигтай бичил биетний био бэлдмэлээр хийх /EM, уусмалаар/;</li> <li>- Нүхэн жорлон, бохирын цооногийн орчмын /3-4 м<sup>2</sup> талбай/ хөрсөнд ариутгал халдвартгүйжүүлэлт хийх;</li> <li>- Жорлонгийн гадаргууд бүх төрлийн шавжны авгалдай, нян устгах зэрэг ажлыг нэг удаагийн үе шаттай хийж гүйцэтгэн.</li> </ul> <p>Анхаарах: Ариутгал халдвартгүйжүүлэлт хийхээс өмнө болон дараа нүхэн жорлон, бохирын цооног орчмын хөрснөөс дээж авч бохирдлын хэмжээг итгэмжлэгдсэн мэргэжлийн лабораториор тодорхойлуулна.</p> <p>Хөрсний дээж аваходаа дүүргийн Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн асуудал хариуцсан мэргэжилтэн, хорооны Засаг дарга нарыг газар дээр нь байлцуулж, акт үйлдэж, хөрсийг битүүмжилж лацдан мэргэжлийн лабораториид хүргүүлнэ. Лабораторийн шинжилгээтэй холбоотой гарах зардлыг гүйцэтгэг хариуцна.</p>
6	Ариутгал халдвартгүйжүүлэх бодис	<ul style="list-style-type: none"> <li>- Ариутгал халдвартгүйжүүлэлт хийх бодис, бэлдмэл нь Монгол улсад хэрэглэхийг зөвшөөрсөн мэргэжлийн байгууллагын дүгнэлт, зөвшөөрөлтэй байх ба тендерийн баримт бичигт хавсаргаж ирүүлнэ.</li> </ul>
7	Эдийн засгийн тооцоо, төсөв	<ul style="list-style-type: none"> <li>- Эдийн засгийн тооцоо болон төсвийг БНБД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцно.</li> </ul>
8	Ариутгал халдвартгүйжүүлэлт хийхэд мөрдөх дүрэм, журам, стандарт	<ul style="list-style-type: none"> <li>- "Ахуйн шавж, мэрэгч устгах, халдвартгүйжүүлэлт. Гуравдугаар хэсэг. Үйлчилгээ" MNS 5161-3:2002 стандарт</li> <li>- Мэргэжлийн хяналтын Ерөнхий тазрын даргын 2017 оны А/179 дүгээр тушаалын долоодугаар хавсралтаар батлагдсан "Ахуйн шавж, мэрэгч устгал, халдвартгүйтгэлийн үйл ажиллагаанд мөрдөх эрүүл ахуй, халдварт хамгааллын үлгэрчилсэн дүрэм"</li> </ul>
9	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>- Үйлчилгээний нэр /шавж устгал, мэрэгч устгал, халдвартгүйжүүлэх үйлчилгээ гэх мэт/, хэрэглэсэн бодисын нэр, тусгасан тэмдэглэлийг 2 хувь бичиж, үйлчлүүлэгчийн үнэлгээ, гарын үсгийг зуруулан нэг хувийг байгууллага, иргэнд үлдээх;</li> <li>- Химийн бодисоор хордох, осол гэмтэл гарах эрсдэлээс сэргийлж, үйлчилгээний өмнөх болон дараах санамж анхааруулгыг үйлчлүүлэгч байгууллага, иргэдэд сайтар танилцуулж, гарын үсэг зуруулж баталгаажуулах;</li> <li>- Бодис асгарсан, цацагдсан, түүнд хордсон үед шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хор, бодисыг саармагжуулах уусмал зэрээр зайлшгүй хангаж, хэрэглээнд хяналт тавих;</li> </ul>


ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 10, 11, 12, 13, 14, 16, 21, 22, 23 ДУГААР ХОРООДЫН АРИУТГАЖ  
ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ НҮХЭН ЖОРЛОН, БОХИРЫН ЦООНГОГИЙН СУДАЛГАА

№	Хороо	Нийт нүхэн жорлонгийн тоо	Бохирын цооногийн тоо
1	10 дугаар хороо	1009	563
2	11 дүгээр хороо	23	19
3	12 дугаар хороо	371	656
4	13 дугаар хороо	821	378
5	14 дүгээр хороо	1650	560
6	16 дугаар хороо	1096	906
7	21 дүгээр хороо	16	0
8	22 дугаар хороо	46	0
9	23 дугаар хороо	73	0
	НИЙТ	5105	3082

ХЯНАСАН:  
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:  
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

  
Г.ТУЯАЦЭЦЭГ

  
Б.ЭРДЭНЭЗУЛ